

МОНГОЛЫН БУЖГИЙН СПОРТЫН ХОЛБООНЫ 2011 ОНЫ САНХҮҮГИЙН ЖУРАМ

1. Ерөнхий зүйл

МБСХ нь МБСХ-ны дүрэм болон энэ журамд заагдсан бүрэн эрхийнхээ дагуу төлбөрийг удирдан захирна. Төлбөрийг төгрөгөөр барьж зарцуулна. МБСХ-ны Улаанбаатар хотын банкны 2611008173 тоот дансаар төлбөр тооцоог хийнэ

2. Элсэлтийн төлбөр

Шинэ гишүүн холбоо, төв, клуб, сургууль, тэнхмүүдийн элсэлтийн төлбөр 30000 төгрөг байх ба хураамжийг нэг сарын дотор МБСХ-ны гишүүнчлэлийн бүртгэлийн мөнгөн орлогоор тушаана.

3. Гишүүнчлэлийн жил бүрийн татвар

3.1. Гишүүний зэрэглэл:

3.1.1. Гишүүн холбоод	100000 төгрөг
3.1.2. Гишүүн клуб, төв, сургууль, тэнхимүүд	100000 төгрөг
3.1.3. Формейшн хамтлаг	100000 төгрөг
3.1.4. Хувь хүн	30000 төгрөг
3.1.5. Хүндэт гишүүд	0 төгрөг

3.2. Татварын хугацаа:

Гишүүнчлэлийн жил бүрийн татварыг жил бүр 1-р сарын 1-нээс эхлэн 3-р сарын 1-нээс оройтуулалгүй тушаана.

4. Тэмцээн уралдааны зөвшөөрлийн төлбөр

4.1. Хууль зүйн эрх

МБСХ-ны тэмцээний дүрэмд заагдсан болон бусад тэмцээнүүдийг зохион байгуулах эрхийн төлбөрийг Тэргүүлэгчдээс тогтооно.

4.2. Зөвшөөрлийн төлбөр

5 хүртэлх орон оролцсон нөхөрсөг тэмцээн	100000 төгрөг
МБСХ УАШТ тэмцээн	100000 төгрөг
МБСХ Цомын аварга шалгаруулах тэмцээн	50000 төгрөг
МБСХ Бүсийн АШТ, УБ хотын АШТ	50000 төгрөг
Улсын чанартай нэрэмжит тэмцээн	50000 төгрөг

4.3. Төлбөрийн хугацаа

МБСХ-ны гишүүн холбоо, клуб, байгууллага, хувь хүмүүс тэмцээн зохион байгуулах зөвшөөрлийн төлбөрийг тэмцээн эхлэхээс наад зах нь 60 хоногийн өмнө тушаана. Төлбөрийг зээл эсвэл нэхэмжлэл хэлбэрээр хийж болохгүй.

5. МБСХ-ны шүүгчдийн эрхийн төлбөр

МБСХ-ны шүүгчдийн эрхийн төлбөр болох 15000 төгрөг Тэргүүлэгчдээс жил бүр тогтооно.

6. Торгууль

6.1. Энэ журамд заагдсан төлбөрийг цаг тухайд нь төлөөгүй гишүүн холбоо, клуб, сургуулиуд, шүүгчид нэмж илгээсэн нэхэмжлэх тутамд торгуулийн 20000 төгрөг нэмж төлнө.

6.2. Тэмцээн зохион байгуулахаас татгалзсаны торгууль

Тэмцээн явуулахаар тогтсон хугацаа хүртэл 30 хоногийн дотор тухайн арга хэмжээг явуулахаас татгалзсан тохиолдолд 50000 төгрөгийн торгууль төлнө.

7. Хүчин төгөлдөр болох хугацаа

Энэхүү санхүүгийн журмыг 2010 оны 1-р сарын 31-ний өдрийн МБСХ-ны бүх гишүүдийн хурлаар шинэчлэн баталсан бөгөөд 2010 оны 2-р сарын 1-нээс эхлэн мөрдөгдөнө.